



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар ТЭА-2019/17 | СТА-ТТЗ-82/122 Зуунмод

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төв аймгийн Сэргэлэн сумын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ан агнуурын нөөцийн төлбөрийн 8 сард орсон 44,800.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт байгууллагын өөрийн орлого гэж зөрүүтэй мэдээлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлангийн аудитын "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 -д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", МУЕА-ын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 12 бүлгийн аудит хийх үе шатны 12.11-д "аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг залруулах боломж байгаа эсэхийг эхэлж шийдвэрлэх бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийн шинж байдлаас нь хамааран дараах шийдвэрүүдийн аль нэг хэлбэрээр эцэслэн шийдвэрлэж баримтжуулан баталгаажуулна" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2019.06.01-ний дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэргэлэн сумын засаг дарга Э.Энхбаяр, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Отгонхуяг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН²:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Ц.БАЗАРСАД

ЗӨВШӨӨРСӨН:
ЗАСАГ ДАРГА Э.ЭНХБАЯР
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.ОТГОНХУЯГ

² Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.